



МОНГОЛ УЛС
ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2013 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/53

Чийр

Дэд зөвлөл, ажлын хэсэг байгуулах тухай

"Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 30.1.5 дахь заалт, Засгийн газрын 2012 оны "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах зарим арга хэмжээний тухай" 222 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэх ажлыг удирдлагаар хангах, хянан зохицуулах үүрэг бүхий дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг Нэгдүгээр хавсралтаар, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хууль тогтоомжид нийцүүлэн олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг удирдлага зохион байгуулалт, хяналт, зохицуулалтаар хангаж ажиллахыг зөвлөлд, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг бүх шатанд хэрэгжүүлж ажиллахыг ажлын хэсэгт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ОТГОНЖАРГАЛ

Аймгийн Засаг даргын 2013-оны
06 сарын 22 ны өдрийн 1/13 дугаар
Захирамжийн 1 дугаар хавсралт

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧЛАГЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЯНАН ЗОХИЦУУЛАХ
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга: Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга: Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн
дарга
Гишүүд: Аймгийн ИТХ-ын Нарийн бичгийн дарга
Аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн дарга
Шивээ Овоо ХК-ийн гүйцэтгэх захирал
Шинэ Шивээ ХХК-ийн захирал
Хотол чойр ИНСүлжээний тэргүүн
Монголын Байгаль орчныг хамгаалах холбооны
салбар зөвлөлийн тэргүүн